



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

20 /234/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.26

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 013 ДУГААР АНГИД АЖИЛЛАВ

1933 он.

Монгол Улсын хил хязгаарын хамгаалалтын зарим хэсгийг Дотоодыг Хамгаалах газарт шилжүүлжээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-32

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,225.0	3,235.0
CNY	450.50	451.50
RUB	37.00	38.00
JPY	24.93	25.05
KRW	2.38	2.39

ЗУРХАЙ

2022.01.26 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 24/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ДӨРВӨН НОГООН ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.27-17.42

Барилдлага:

Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Төрөн түгэхүй

Суудал:

Хий

Аргын тооллын 1 сарын 26, Буд гараг. Билгийн тооллын 24, Салхины эх одтой, шарагчин туулай өдөр. Өдрийн наран 8 цаг 27 минутад мандан, 17 цаг 42 минутад жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, сэтгэлд сэтгэй газар очих, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны БХЗГ-ын дарга хурандаа Б.Түвшинтөр, ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга бригадын генерал М.Мөнхбаяр, ЗХЖШ-ын Холбооны хэлтсийн дарга хурандаа М.Золзаяа нар өнөөдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангид ажиллалаа. Тус ангийн захирагч хурандаа Ч.Эрдэнэболд ангийн товч танилцуулга, үүрэг гүйцэтгэлт, өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэлийн онцлог, өнгөрсөн онд хийсэн зарим бүтээлч ажил, цаашид хийхээр төлөвлөж буй ажлын талаар мэдээлэл өгөв.

Зэвсэгт хүчний 013 дугаар анги нь 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлээ

тасралтгүй явуулж ирсний дээр цахим сургалтыг сургалтын арга барилдаа өргөнөөр нэвтрүүлж байна. Түүнчлэн тус ангийн Радио электроникийн туршилт судалгааны төв нэлээд үр дүнтэй ажиллаж буй тухай танилцуулгын үеэр дурдав. Тухайлбал, "Монрадио 1000" болон шууданч дронуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа бөгөөд цаашид төрийн цэргийн бусад байгууллагуудад тухайн төхөөрөмжүүдийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа аж. Үүнээс гадна өнгөрсөн онд буюу Цэргийн холбооны 100 жилийн ойн хүрээнд ангийн байрлалд багагүй бүтээлч ажлыг өрнүүлжээ.

Түүнчлэн ангид тулгамдаад байгаа хэд хэдэн асуудлыг энэ үеэр хөндөж байлаа.

Тодруулбал, тус ангийн барилгуудын насжилтаас үүдэн дэвэрүүд муудсан учир засварлах зайлшгүй шаардлагатай байгааг дуулгав. Үүний хариуд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай "Дэвэр төслийн хүрээнд эхний ээлжид хөдөө орон нутагт байрлаж байгаа анги, салбаруудын барилгуудын дэвэрийг засварлаж байна. Гэсэн хэдий ч нэн шаардлагатай цэргийн байр, гал тогоо зэргийн дэвэрийг засах асуудлыг нааштайгаар шийдэх болно" гэв.

Үргэлжлүүлээд цэргийн байр, Радио электроникийн туршилт судалгааны төв болон ангийн тавилангийн үйл ажиллагаатай танилцсан юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АВАРГА ШАЛГАРУУЛАХ "ЦЭРЭГЖЛИЙН ГИМНАСТИК"-ИЙН ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



Ж а н ж и н Д . С ү х б а а т а р ы н мэндэлсний 129 жилийн ойг угтан ҮБХИС-ийн нэрэмжит Зэвсэгт хүчний аварга шалгаруулах "Цэрэгжлийн гимнастик"-ийн тэмцээн өчигдөр эхэллээ. Тэмцээнд Зэвсэгт хүчний 30 орчим ангийн 280 гаруй цэргийн алба хаагч сонс эргэлт, модон моринд малгай тавьж харайх, олон төрөлт, чөлөөт хөдөлгөөн гэсэн төрлүүдээр өрсөлдөж байгаа бөгөөд өнөөдөр өндөрлөх юм.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

I ТУН	II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ I ТУН
2,268,377 +/69,7%/	2,168,827 +/66,7%/	979,390 +/30,0%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
7812 +112	200	7496

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 339,146,038
Эдгэрсэн
Нийт: 272,803,813
Нас барсан
Нийт: 5,583,023



Монгол цэрэг энхийнүйлсэд

АНХНЫ ХОЁР ОФИЦЕР



мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн) нарыг БНАКонго Улсад явагдаж буй НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд ажиглагч офицероор үүрэг гүйцэтгүүлэхээр илгээсэн нь монгол цэргийн энхийн төлөө их үйлсийн эхлэл байлаа.



2001 онд "Цэрэг, цагдаагийн алба хаагчийг НҮБ-ын энхийг сахиулахын болон Олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" Монгол Улсын хууль батлагдаж, Зэвсэгт хүчнээс дэд хурандаа Ч.Ерөөлцэнгэл, Р.Даваадорж, Ч.Өлзийбаяр, хошууч Д.Ганхуяг, Б.Эрдэнэбаяр, ахмад Н.Наранбаатар, ахлах дэслэгч Б.Ариунболд нарын 7 цэргийн алба хаагчийг

2002 оны 5 дугаар сард Иран Улсад НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах тухай Монгол Улсын хууль батлагдаж, Зэвсэгт хүчнээс дэд хурандаа Ч.Ерөөлцэнгэл (тухайн үед ЗХЖШ-ЭДАГ-ын мэргэжилтэн), дэд хурандаа Р.Даваадорж (ЗХЖШ-Эрүүл

МОТБУУДЛАГЫН БАТАЛЬОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай UNMISS энхийг дэмжих ажиллагааны "Юнити" секторын командлагч бригадын генерал Майк Күүпер Мужуни "Юнити" секторын ажиллагааны удирдлагын даргын хамт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр "Хубилай" баазад айлчилж, Монгол Улсын Зэвсэгт хүчний XI ээлжийн мотобуудлагын батальоны үйл ажиллагаатай танилцлаа. "Юнити" секторын командлагчийг мотобуудлагын батальоны захирагч хурандаа О.Заяат ажиллагааны ахлах офицер дэд хурандаа Н.Гэрэлбадрах болон удирдлагын бие бүрэлдэхүүн хүлээн авлаа.



"Юнити" секторын командлагч бригадын генерал Майк Күүпер Мужуни-ийг мотобуудлагын батальоны хүндэт харуул угтан авч,

хүндэтгэл үзүүлсний дараагаар, мотобуудлагын батальоны үйл ажиллагааг, үүрэг гүйцэтгэлт, харуул хамгаалалтын талаар танилцуулж, мөн секторын

командлагч цэргийн алба хаагчдын амьдардаг байр, орчин нөхцөлтэй танилцаж, цэргийн алба хаагчдын үйлчлүүлдэг номын сан, нэгдүгээр шатлалын эрүүл мэндийн төв, штабтай танилцан үйл ажиллагааны төгсгөлд дурсгалын зураг татуулж санал сэтгэгдлээ солилцлоо.

Бригадын генерал Майк Күүпер Мужуни мотобуудлагын батальоны "Хүндэт зочны дэвтэр"-т үлдээсэн сэтгэгдэлдээ: "Монбэт 11-ийн бүрэлдэхүүн та бүхэнд энхийг сахиулах хүмүүнлэгийн үйл хэргийн төлөөх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг хүсье. Та нар бол БНӨСУ-ын иргэдийн итгэл найдвар мөн UNMISS ажиллагааны бахархал юм" гэж тэмдэглэсэн байна.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

ЭНХИЙГ САХИУЛАГЧ ААВ ХҮҮДЭЭ ЗАХИДАЛ ИЛГЭЭЛЭЭ

Мотобуудлагын батальоны хуягт тээвэлэгчийн ротын ахлагч Алтангэрэлийн Энхмандах нь албаа нэр төртэй хааж байна. Хөөрхөн бяцхан үр Мөнхмандуул нь захиагаар аавдаа бэлэг барьлаа. Ахлагч А.Энхмандах нь нийт 5 удаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай нэгэн, түүний үрээ гэх сэтгэл захианд нь шингэсэн билээ. Та бүхэнд Энхмандахын хүүдээ бичсэн захиаг хургэж байна.

Сайн байна уу? Аав нь хүүгийнхээ захидлыг хүлээн авлаа. 5 настай хүүгээ эрдэмд ийм сайн суралцаж, сайхан бичиж сурсан мэрийлтэд нь аав нь талархаж байна. Хүүд минь анхны "А" үсэг заасан Х.Ихтамир багшдаа болон гэрийн даалгавар сайн хийлгэсэн ээж А.Батцэцэг, эгч Э.Амин-Эрдэнэ нартаа баярлаж талархсанаа аав нь илэрхийлж байна. Аав нь хүүгээсээ хэдий хол байгаа ч гэсэн зүрх сэтгэлээрээ үргэлж



хамт байдаг болохоор миний хүү аавыгаа санаж болохгүй шүү.

Хэрвээ санаад болохгүй байвал: Зун аавтайгаа бор даагаа унаад хоёулаа хүсэл мөрөөдлөө ярьж байсан тэр мөчөө дурсан

санаарай. Аав нь хүүдээ уншиж өгдөг байсан тэр сайхан шүлгийг санаж байна уу?

Яагаав: Хөх мөнхийн уул гээд

Ургах нарыг духдаж дүнхийнэ

Унах нарыг үүрч ханхайна Нар нь шингэдэггүй Навч нь шарладаггүй Тэр Хөх мөнхийн уул Миний хүүгийн уул Амьдралын алганд алдрайхан сайхан хүү заяахад Адуунаасаа унага ногтолж өгье гэхэд багадаж санагдахаар нь

Тэлмэн зэрэглэн дунд эмнэг адуу шиг цовхчих

Тэр "Хөх мөнх"-ийн уул Мөнх аваргын уул гээд аав нь хүүдээ уншиж байсан аа тодхон санаж байна. За ингээд захидалаа өндөрлөө. Аавын хүү онц сураад багш, ээж, эмээ, өвөө, ах, эгч нарынхаа үгэнд сайн ороорой. Хоолоо сайн идээрэй, эрт унтаж байгаарай аав нь хүүдээ хязгааргүй их хайртай шүү.

Өнөр сайхан гэр бүлийнхээ галыг бадамлуулах хүү минь Өвөгдийн үлдээсэн газар шороондоо эзэн суух хөвгүүн минь

Өргөсөн тангаргаа биелүүлж энхийг сахиулж яваа аав нь

Өр нимгэн сэтгэлдээ үргэлж хамт шүү үр минь ээ.

Хүндэтгэсэн: аав А.ЭНХМАНДАХ

ӨНДӨР НАСТАЙ ИРГЭДЭД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭВ

Хошууч Б.Галбат захирагчтай Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай салбарын бие бүрэлдэхүүн Сар шинийн баярыг угтаж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх хүрээнд

4 дүгээр хорооны иргэн Н.Өлзийбаяр, 3 дугаар хорооны иргэн өндөр настан А.Аюурцэрэн нарт тусламж үзүүлж, сэтгэлийн хандив өргөлөө.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)